

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дараах зүйл, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт:**

“11.1.1.шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчийн туслах;”

#### **2/55 дугаар зүйл:**

#### **“55 дугаар зүйл.Хуульчийн сургалт зохион байгуулах**

55.1.Хуульчийн үргэлжилсэн болон ёс зүйн сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

55.2.Хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулга нь Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, шинээр батлагдсан хууль тогтоомжийг таниулах, хуульчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйг нэмэгдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх дадал төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.”

#### **3/62 дугаар зүйлийн 62.6 дахь хэсэг:**

“62.6.Монголын Хуульчдын холбооны гишүүдийн татвар, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүнчлэлийн хураамжийг давхардуулан авахгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад /шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульч/ олон улсын гэрээ конвенцын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах хөшүүрэг бий болгохоор хуулийн 55 дугаар зүйл буюу хуулийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах гэсэн хэсэгт хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулга нь Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, шинээр батлагдсан хууль тогтоомжийг таниулах, хуульчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйг нэмэгдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх дадал төлөвшүүлэхэд чиглэгдэх агуулга бүхий зохицуулалт нэмэхээр боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Өмгөөллийн тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд Өмгөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулахын Засгийн газарт даалгасны дагуу хуульч, өмгөөлөгчийн хураамжийг сайн дурын үндсэн дээр аль нэг байгууллагад төлдөг болох зохицуулалтыг бий болгохоор тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ